



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 526

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх заалт, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.б дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж, ашиглалтад оруулсан, нийт 1,820,932,171.00 (нэг тэрбум найман зуун хорин сая есөн зуун гучин хоёр мянга нэг зуун далан нэгэн) төгрөгийн үнэ бүхий Гал түймэр унтраах, аврах 80 дугаар ангийн барилгыг нийслэлийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Онцгой байдлын өрөнхий газрын дарга, хошууч генерал Т.Бадрал, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын Ш.Үнэнбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Гал түймэр унтраах, аврах 80 дугаар ангийн барилгыг хүлээлцэх ажлыг комисс томилон зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бурийн задаргаа, зориулалтыг харгалзан, Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэх асуудлыг шийдвэрлүүлэх;

2.3. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0001 2